Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Яамны хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Доржготов Одончимэг

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Яамны үйл ажиллагааны өдөр тутмын тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, төрийн захиргааны байгууллага, харьяа байгууллагын болон салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ. | | | | | | | |
| 1 | Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах; | Батлагдсан бодлогын баримт бичгийн дагуу зохион байгуулсан арга хэмжээний тоо | Хүний нөөцийн бодлогын баримт бичиг батлагдсан. | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн албан тухай хууль, тогтоомж, яамны хүний нөөцийн стратеги ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 онд хүний нөөцтэй холбоотой 223 тушаалын төсөл боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Боловсрол, шинжлэх ухааны яамны нийт албан хаагчдаас 2 төрлийн судалгаа, санал авах ажлыг хийж зохион байгуулж, холбогдох | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шийдвэрийг батлуулан ажиллалаа. Үүнд: Яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах, нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамтруулах тухай зэрэг болно. Ажлын байранд гэмтэл авсан 1 албан хаагчид ОМ тогтоолгохтой холбоотой дүгнэлт бусад баримт бичиг, бичлэгийн бүрдлийг холбогдох хариуцсан аллбан хаагчаар хангуулан шийдвэрийг гаргуулан ажилласан. Мөн албан хаагчдын орон сууцны судалгааг гарган удирдлагад танилцуулсан. 2024 онд жилд яамны албан хаагчдыг дараах сургалтад хамруулав. Үүнд: 1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч 2.Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч 3.Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4 албан хаагч 4.Дунд хугацааны давтан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтад 2 албан хаагч. | | |
| 2 | Яамны хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | Дотоод журмыг үндэслэн гаргасан шийдвэрийн тоо | Дотоод журмын хэрэгжилтийг ханган ажилласан. | Дотоод журмын холбогдох заалтыг хүний нөөцийн шийдвэр гаргахдаа үндэслэн ажилласан байна | Боловсролын яамны хүний нөөцтэй холбоотой шийдвэрийг төслийг боловсруулахдаа яамны хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг үндэслэл болгон ажиллав. Яаманд 2024 онд шинээр томилогдсон албан хаагчийн хувийн хэргийг холбогдох журамд заасан бүрдэлтэйгээр бүрдүүлүүлэн хүлээн авсан. 1. Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн тэтгэмж олгох тухай 3 тушаал 2. Цалинтай цалингүй чөлөө олгох тухай 9 тушаал 3. Мөнгөн тусламж олгох тухай 4 тушаал 4.Сахилгын шийтгэл ногдуулах тухай 3 тушаал тус тус боловсруулан албажуулсан байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 3 | Боловсролын яамны албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулах | Үнэлгээний хувь | 2023 оны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, холбогдох шийдвэр батлах ажлыг зохион байгуулсан. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулах, үнэлж дүгнэн хариуцлага тооцох, урамшуулах шийдвэр гарсан байна. | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Биелэлт дүгнэх үнэлгээний баг байгуулах тухай" А/145 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган яамны нэгжийн болон албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р | Өөрийн үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг үнэлж дүгнэх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ахлах мэргэжилтэн П.Наранжаргалын хамт ажиллав. Ажлын хэсгийн бэлтгэл хангаж, хурлын протокол хөтлөн, урамшууллын шийдвэрийг гарган ажиллав. 2024 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай тушаалын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | сар, 12-р сар | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 4 | Төрийн албаны зөвлөлийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажилласан. | Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна. | Салбар зөвлөлийн даргын 2024 оны 01 дүгээр тогтоолоор Салбар зөвлөлийн ажиллах 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав. Салбар зөвлөл 2024 онд нийт 12 удаа хуралдан албан хаагчдын зэрэг дэв, яам, агентлагийн АТТ-ын төсөл, тусгай болон | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын дүн зэрэг асуудлуудыг хэлэлцэн 65 тогтоол, 5 тэмдэглэл, 51 албан бичиг батлан гаргасан байна. ТАЗ-ийн яамны дэргэдэх салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, тогтоомж, Салбар зөвлөлийн ажиллах журмын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 1. Салбар зөвлөл 2024 онд яам, агентлаг, харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн нийт 71 сул ажлын байранд 20 удаагийн шалгалтыг зохион байгуулж, дүнг Салбар зөвлөлийн хуралд танилцуулан, тусгай шалгалт өгч тэнцсэн 43 иргэнийг томилуулахаар нэр дэвшүүлсэн тогтоолыг албажуулав. 2. 2024 онд нийт давхардсан тоогоор 71 сул ажлын байрны зарыг яам агентлаги, ТАЗ-ийн цахимд хуудсанд байршуулсан. Ажлын байранд бусад төрийн байгууллагаас шилжин, | | байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэлгэн ажиллах албан хаагчийн хүсэлтийг хүлээн авах, нөхөгдөөгүй ажлын байранд тусгай шалгалт зохион байгуулах ажлыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар батлагдсан журмын дагуу үе шаттайгаар зохион байгуулж, тусгай шалгалтын нээлттэй зарлан зохион байгуулсан. 3. Яам, агентлагийн албан хаагчдад зэрэг дэв олгох, ахиулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. 4. Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн боловсролыг газар, аймгийн Боловсролын газрын удирдах болон гүйцэтгэх аолбан тушаалын АТТ-ын төслийг хэлэлцэн, ТАЗ-д хүргүүлэн батлах зөвшөөрөл авсан. 5. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтийг ТАЗ-д хүргүүлж, ажлаас чөлөөлөгдсөн гишүүнийг гишүүнээс чөлөөлж 3 гишүүн нэмж ТАЗ-ийн тогтоолоор баталгаажуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 6 файл | | |
| 5 | Яам, агентлаг болон харьяа байгууллагын сул орон тооны судалгаа гаргах, захиалга өгөх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. | Сул ажлын байрны тоо, Зохион байгуулсан сонгон шалгаруулалтын тоо, үр дүн | Сонгон шалгаруулалт амжилттай зохион байгуулагдсан. | Сул орон тоо нөхөгдсөн байна | Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, аймгийн Боловсролын газрын 2024 онд бий болсон сул орон тооны судалгааг гаргаж удирдлагад тухай бүр танилцуулан ажиллав. Сайдаас ирүүлсэн яамны харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тооны захиалгыг Салбар зөвлөлийн хуралд танилцуулж, шалгалт зохион байгуулах шийдвэр гарган зохион байгуулсан. Яам, агентлагийн сул ажлын байрны зарыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар батлагдсан журмын дагуу нөхөх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллав. Энэ ажлын хүрээнд яамны сул албан тушаалын зарыг яамны болон ТАЗ-ийн, агентлагийн цахим хуудсанд 5 хоног тус тус байршуулж, Журмын хүрээнд төрийн бусад байгууллагаас зарын дагуу шилжин болон | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэлгэн ажиллах иргэний хүсэлт ирээгүй ажлын байранд тусгай шалгалт зохион байргуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн нээлттэй зарлах ажлыг зохион байгуулсан. Салбар зөвлөл 2024 онд яам, агентлаг, харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн нийт 71 сул ажлын байранд 20 удаагийн шалгалтыг зохион байгуулж, дүнг Салбар зөвлөлийн хуралд танилцуулан, тусгай шалгалт өгч тэнцсэн 43 иргэнийг томилуулахаар нэр дэвшүүлсэн тогтоолыг албажуулав. Салбар зөвлөлийн тогтоолыг үндэслэн тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авсан иргэдийн сул ажлын байранд томилох шийдвэрийг Боловсролын сайд, ТНБД-ын болон БЕГ-ын даргын тушаалаар баталсан болно. 2024 онд Боловсролын яамны 4 эрхэлсэн түшмэлийн сул ажлын байранд тусгай шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үндэслэн 4 иргэнийг албан тушаалд томилон ажиллуулсан. Хавсралт: 24 файл | | |
| 6 | Яамны албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | Сургалтын тоо, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Яамны албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан. | Албан хаагчдын ажиллах нөхцөл хэвийн, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж, илүү цагаар өндөр бүтээмжтэй ажилласан албан хаагчдыг урамшуулах эдийн засгийн орчин бүрдсэн байна. | Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин зургаадугаар дугаар зүйлийн 3, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 онд дараах ажлыг хэрэгжүүлэн шийдвэрлүүлж ажилласан. Үүнд: 1.Төрийн захиргааны албанд тасралтгүй 5 жил түүнээс дээш хугацаагаар ажилласан аймгийн Боловсролын газрын дарга нарт холбогдох мөнгөн урамшууллыг олгосон. 2.Яамны хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн 28 албан хаагчид 1-3 сарын цалинтай тэнцэх нийт 122,348, 293 мөнгөн дэмжлэг үзүүлсэн. 3.Боловсрол, шинжлэх ухааны яамны албан албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний биелэлтийг үнэлүүлэн урамшуулал олгосон. 4.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2 дахь заалт, 46.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.2 дахь хэсгийг үндэслэн ажилласан хугацаанд ногдох нэг удаагийн буцалтгүй тусламжийг 3 албан хаагчид олгохоор ТНБД-ын тушаалаар шийдвэрлэсэн. 5.Яамны 3 албан хаагчид нийт 3 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгож ТНБД-ын тушаалаар шийдвэрлэсэн. 6.Яамны 9 албан хаагчид 7-14 хоногийн цалинтай болон цалингүй чөлөө олгож ТНБД-ын тушаалаар шийдвэрлэсэн. 7.Яамны нийт албан хаагчдын 2024 оны ээлжийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | амралтыг биеэр эдлэх тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан. 8.Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, яамны албан хаагчдын хоолны мөнгө 25000 төгрөг байсныг 30000 төгрөгөөр тогтоож Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд шинэчлэн оруулсан болно. | | |
| 7 | Яамны хүний нөөцийн чадавхыг сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулах | Сургалтын тоо | Сургалтад хамрагдсан. | 2024 оны сургалтын төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна. | 2024 онд жилд яамны албан хаагчдыг дараах сургалтад хамруулав. Үүнд: 1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч 2.Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч 3.Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4 албан хаагч 4.Дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч. Мөн Боловсролын яам болон харьяа байгууллагын албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлийн 7*4*10 цахим сургалтад хамруулах ажлыг зохион | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллалтаар ханган ажиллаж, сургалтад албан хаагчид идэвхитэй хамрагдлаа. Албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны хулийн төслийг сурталчлах, хэлэлцүүлэг зохион байгуулах сургагч багшийн сургалтад хамруулахаар хүсэлтийг ЗГХЭГ-т хүргүүлж, сургалтад албан хаагчид хамрагдсан. Хүний нөөцийн удирдлагын системийг шинэчлэн хөтлөх болсонтой холбогдуулан ТЗУГ-ын дарга болон холбогдох албан хаагчдыг сургалтад хамруулсан. "Төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг сайжруулах", "Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулах" сэдэвт сургалт хэлэлцүүлэгт яамны хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч, хяналт - шинжилгээ, хариуцсан ахлах шинжээч, Боловсролын ерөнхий газрын 1 хэлтсийн даргыг хамруулсан. Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай" 165 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган Боловсролын яамны албан хаагчдыг монгол бичигт сургах, монгол бичгээр баримт бичиг төлөвлөх, боловсруулах, албан хэрэг хөтлөх, цахим орчинд хэрэглэх чадвар эзэмшүүлэх зорилгоор дотооддоо Монгол бичгийн сургалтыг зохион байгуулж албан хаагчид идэвхитэй хамрагдаж байна.<br>Хавсралт: 24 файл | | |
| 1.2. Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | | | | | | | |
| 8 | Яамны хүний нөөцийн холбогдох мэдээллийг бэлтгэн өгөх | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээллийг бэлтгэн өгсөн байна | Холбогдох мэдээллийг ил тод болгосон. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээллийг бэлтгэн өгсөн байна | Боловсролын яамны цахим хуудсанд 2024 онд дараах мэдээллийн байршуулан ажиллав. Үүнд: 1. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу яам харьяа байгууллагын сул орон тоонд төрийн өөр байгууллага, нэгж | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хооронд "Шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай" нийт 28 удаагийн зар 2. Боловсролын яамны Төрийн жинхэнэ албан хаагчдын нийт 103 ажлын байрны "Албан тушаалын тодорхойлолт" 3. Боловсролын яамны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө-2024 он" Мөн Боловсролын яамны албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, яам харьяа байгууллагын сул орон тооны мэдээллийг тухай бүр гарган Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан ажилласан бөгөөд Сул орон тооны судалгаанд үндэслэн тусгай шалгалтыг зохион байгуулж, хүний нөөцийн нөхөлтийг хууль тогтоомжийн хүрээнд томилгоог хийх ажлыг зохион байгуулсан. 4. Үндэсний аудитын газраас 2013-2023 оны хүний нөөцийн үйл ажиллагаанд аудит хийсэнтэй холбогдуулан холбогдох мэдээлэл судалгааг /4 төрлийн 78 талбар бүхий / гарган хүргүүлсэн. 5. Төрийн албан зөвлөлөөс яамны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүний нөөцийн томилгооны асуудал шалгалт хийсэнтэй холбогдуулан мөн холбогдох мэдээлэл судалгаа, тушаал шийдвэрийн цаг тухайд нь гарган өгч ажилласан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.1. Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 9 | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Төлөвлөгөөний биелэлт хангагдсан. | Төрийн жинхэнэ албан хаагчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. | Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг журамд заасан хугацаанд батлуулан, системд оруулж, биелэлтийг сар тутамд болон хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллав. Мөн БШУЯ-ны 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны "Төлөвлөгөө батлах тухай А/63 тоот тушаалаар албажуулсан бөгөөд төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газрын " Авлигын эсрэг цахим систем"-д бүртгэн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар тайлагнасан. Хууль тогтоомж, бодлогын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баримт бичиг, тогтоол шийдвэрт туссан яамны хүний нөөц, ил тод байдал, ёс зүйтэй холбоотой заалтын биелэлтийг тухай бүрд нь гарган холбогдох албан хаагчид хүргүүлэн ажиллав. Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны эхний хагас жилийн тайлан болон, ёс зүй гомдол маргааны тайлан, мэдээг хугацаанд нь гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв. Төрийн албан зөвлөлөөс яамны 2024 оны хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд аудит хийсэнтэй холбогдуулан яамны сул, эзэнгүй орон тооны судалгаа болон , хүүхэд асрах чөлөөтэй, сургалтын чөлөөтэй албан хаагчийн судалгааг гарган хүргүүлсэн болно. Мөн Үндсэний аудитын газраас яамны 2013-2023 оны хүний нөөцийн барим бичигт аудит хийсэнтэй холбогдуулан шаардсан судалгаа мэдээг хугацаанд гарган хүргүүлсэн. Дээрх судалгаа нь томоохон хэмжээний судалгаа | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл бөгөөд Хүний нөөцтэй холбоотой мэдээлэл судалгаа нь хувь хүний нууцад хамаардаг тул судалгааг хавсаргах боломжгүй байна. Хавсралт: 3 файл | | |
| 10 | Хариуцсан ажлын үндсэн чиг үүргийн дагуу холбогдох ажлын хэсэг, комиссын бүрэлдэхүүнд ажиллах, биелэлтийг тайлагнах; | Ажилласан ажлын хэсгийн тоо | Холбогдох ажлын хэсэгт ажилласан. | Шинээр болон шинэчлэгдэн гарсан хууль, дүрэм журмуудыг уншиж судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана. | Дараах ажлын хэсэгт нарийн бичгийн дарга, гишүүнээр ажиллав. Үүнд: 1. Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргын "Шалгалтын комисс байгуулах тухай" 2024 оны 07, 18, 21, 42, 47 дугаар тогтоолоор Яамны сул орон тоо, 7 аймгийн боловсролын газрын даргын албан тушаалын сул орон тооны тусгай шалгалт зохион байгуулах "Шалгалтын комисс"-ын нарийн бичгийн дарга, гишүүнээр ажиллаж шалгалтыг амжилттай зохион байгууллаа. 2. ТНБД-ын 2024 оны Б/15, Б/30, А/29 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Албан тушаалын төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн албаны зөвлөлийн Зөвшөөрөл олгох тухай 347,349, 350, 440, 441 дүгээр тогтоолын дагуу шинээр 33, шинэчилсэн-6, өөрчлөлт оруулсан 80, нийт 109 албан тушаалын тодорхойлолтыг ТНБД-ын 2024 оны А/13, А/20, А/21, А/81, А/82 дугаар тушаалаар батлууллаа. 3. Сайдын 2024 оны Б/29, Б/26 дүгээр тушаалаар байгуулагдсан харьяа байгууллагын дарга нарын ажил хүлээлцэх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж ажил хүлээлцэх үеийн протокол, актыг үйлдэж тамга тэмдгийг амжилттай хүлээлгэн өгсөн болно. Хавсралт: 8 файл | | |
| 11 | Баримт бичгийг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь бүрэн бүрдэлтэйгээр архивд хүлээлгэн өгнө. | Архивд хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо | Холбогдох материалыг архивд хүлээлгэн өгсөн. | Яамны хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтад заасан баримт бичгийг архивд хүлээлгэн өгсөн байна. | Харьяа байгууллагын захирлуудын сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон түүний хагас бүтэн жилийн биелэлт, хариутай албан бичиг зэрэг 44 нэгж баримт бичгийг архивд хүлээлгэн өгсөн. Хавсралт: 3 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 12 | Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг шуурхай, чанартай, гаргаж өгсөн байна. | Судалгаа мэдээллийн тоо | Холбогдох судалгааг хугацаанд нь гаргасан. | Мэдээ, мэдээлэл, судалгааг хугацаанд нь гарсан байна. | Дараах судалгаа мэдээллийг цаг хугацаанд нь удирдлагууд болон холбогдох байгууллагад хугацаанд нь гарган өгч ажиллав. Үүнд: 1. Боловсролын салбарын хөжлийн бэрхшээлтэй багш, ажилтаны тоо /Дотоод албан бичгээр ТХСБХ-ээс ирсний дагуу Цахим боловсролын газраас судалгааг нэгтгэн ахлах мэргэжилтэн Г.Амаржаргалд хүргүүлсэн./ 2. АҮЭБЯ болон ЭЗХЯ-ны хүний нөөц хариуцсан албан хаагчид БШУЯ-аас тус яамдуудад шилжсэн нийт 12 албан хаагчийн холбогдох мэдээлэл судалгаа 3. Багш нарын баяр болохтой холбогдуулан Боловсролын яаманд ажиллаж буй Багш мэргэжилтэй албан хаагчийн судалгаа 4. Албан хаагчдын орон сууцны судалгаа 5. Яамны сул, эзгүй орон тоо болон , хүүхэд асрах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чөлөөтэй, сургалтын чөлөөтэй албан хаагчийн судалгаа /Төрийн албаны зөвлөлөөс хүний нөөцийн аудит хийсэнтэй хологдуулан гаргаж өгсөн/ 6. Монгол Улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар төрийн албаны чадавхи бэхжүүлэх чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа хөтөлбөр, төсөл арга хэмжээний судалгаа мэдээлэл /Яамны ГХАГ болон харьяа байгууллагуудаас авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн/ 7. Яамны харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороо байгуулан ажиллаж байгаа эсэх тухай судалгаа /Судалгааг нэгтгэн Төрийн албаны Ёс зүйн хороонд хүргүүлсэн/ 8. Аймгийн боловсролын газрын дарга нарын сул орон тооны судалгаа 9. Боловсролын яамтай хамтран үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ТББ-ын судалгаа 10.Удирдлагын академийн төрийн албанд анх томилогдсон, чиглүүлэх дунд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацааны, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах албан хаагчийн судалгаа 11.Зэрэг дэвийн судалгаа 12. Харьяа байгууллагын Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчийн судалгаа / Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн талбарын дагуу гарган хүргүүлсэн/ 13. 2013-2023 оны яамны хүний нөөцийн судалгаа /Үндэсний аудитын газраас ирүүлсэн 72 талбар, 3 sheet-ийн дагуу гарган хүргүүлсэн./ 14. Боловсролын салбарын хэмжээнд 2023 оны ХАСХОМ гаргах албан хаагчдын судалгаа /Яам харьяа байгууллагаас авч нэгтгэн АТГ-т хүргүүлсэн/ Хавсралт: 6 файл | | |
| 13 | Эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах асуудлаар байгууллага, албан тушаалтан, иргэнээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судлан журамд заасан хугацаанд хариу өгнө. | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо | Албан бичиг өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн. | Хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд 2024 он 12 сарын байдлаар нийт 223 албан бичиг, 87 өргөдөл хүлээн авч нийт 255 албан бичиг, өргөдлийн хариуг боловсруулан бусад байгууллагад хүргүүлэн ажилласан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Удирдлагын академаас зохион байгуулсан сургалтад амжилттай хамрагдаж төгссөн байна. | Сургалтад хамрагдсан байна. | Холбогдох сургалтуудад хамрагдсан. | Эзэмшсэн мэдлэг чадвараа ажил үүрэгтэй байнга тусган хэрэгжүүлсэн байна. | 1. Удирдлагын академиас зохион байгуулсан "Төрийн чадамжийг бүрдүүлэх нь:Асуудлыг тодорхойлж, системтэйгээр шийдэл хайх аргачлал" сургалтад 2024 оны 01 дүгээр сарын 25,26, 02 дугаар сарын 05-ны өдрүүдэд хамрагдаж, сургалтын хөтөлбөрийн хүрээнд 24 цагийн хичээл судлан амжилттай төгссөн болно. 2. Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал" сэдэвт хэлэлцүүлэг болон "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ийн талаарх сургалтад яамны холбогдох дарга албан хаагчдын хамт оролцов. 3. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу "21 дүгээр зууны боловсрол-Насан туршийн суралцахуй" сэдэвт мэдээлэллийн цагт, Нура төвийн их эмч С.Цэрэнпагма "Витамины хэрэглээ болон багц оношилгооны талаар" сэдэвт мэдээллийн цагт, Философийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М. Анара (Ph.D) "Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент" сэдэвт мэдээллийн цагт тус тус хамрагдлаа. 4. Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн Пүрэв гариг бүр зохион байгуулагддаг Төрийн албан хаагчдад зориулсан 7*4*10 цахим сургалтад тогтмол цахимаар хамрагдсан.<br>Хавсралт: 21 файл | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Яамны хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Доржготов Одончимэг /................................................./ Огноо: .........................